



ЭРХ ЧӨЛӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ НАМД

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.04.21 № 1196
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох “Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам”-аас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020” Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

“Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам”-ын Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3. дахь хэсэг, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам”-ын мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сонгуулийн Ерөнхий хороонд

Д.ЗАНДАНБАТ